



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАРИМ ГҮЙЦЭТГЭГЧ КОМИССООС ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫГ
БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2023/28-16-ШТА-ГА

Баруун-Урт 2023 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганццэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.	5
<i>А.1. Зарим төсөл арга хэмжээ нь монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.....</i>	<i>5</i>
<i>А.2. Зарим төсөл арга хэмжээг төсвийн тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүй байна.....</i>	<i>7</i>
БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ ЗӨРЧЛҮҮД ГАРЧ БАЙНА.	9
<i>Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна....</i>	<i>9</i>
<i>Б.2. Зарим гүйцэтгэгч комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байна.</i>	<i>11</i>
<i>Б.3. Зарим төсөл арга хэмжээний нэмэлт гэрээ, олгосон санхүүжилт хууль, журамд нийцэхгүй байна.</i>	<i>14</i>
<i>Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих техникийн улсын хяналт хангалтгүй, ТЕЗ-ийн дотоод хяналт хэрэгжээгүй байна.....</i>	<i>16</i>
<i>Б.5. Зарим төсөл арга хэмжээний хувьд улсын комиссын үүрэг даалгавар биелээгүй байна.....</i>	<i>17</i>
БҮЛЭГ В. ТӨЛӨВЛӨЛТ, ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙГ ЭС ТООЦВОЛ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.	20
<i>В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй зөрчлүүд гарч байна.....</i>	<i>20</i>
<i>В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.....</i>	<i>21</i>
Холбогдох байгууллагын санал:	25
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	25
ДҮГНЭЛТ: 26	
ЗӨВЛӨМЖ:.....	26
Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:	27

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 80 жилийн ойгоор хандив өгсөн иргэн, ААНБ	10
Хүснэгт 2	Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа	11
Хүснэгт 3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт	14
Хүснэгт 4	Данс бүртгэлд тусгаагүй эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ	19
Хүснэгт 5	Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл арга хэмжээ	20
Хүснэгт 6	Төсөв батлагдахаас өмнө зураг, төсөв нь баталгаажгаагүй ТАХ	21
Хүснэгт 7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй ТАХ	22
Хүснэгт 8	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын олгосон санхүүжилт	23

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу хийв.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2022 онд хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2023 оны 2 сарын 20-ны өдрөөс 4 сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.

А.1. Зарим төсөл арга хэмжээ нь монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.

А.1.1. "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-той нийцэхгүй хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээ байна.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах 9 зорилт хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

Үндэсний нэгдсэн үнэт зүйлс

- Хүний хөгжил
- Амьдрах чадвар ба дундаж давхарга
- Эдийн засаг
- Засаглал
- Ногоон хөгжил
- Амар тайван, аюулгүй нийгэм
- Бүс, орон нутгийн хөгжил
- Улаанбаатар ба дагуул хот гэж тусгажээ.

“Алсын хараа 2050” хөгжлийн бодлого нь урт хугацаанд өргөн хүрээний бодлого хэрэгжүүлэх баримт бичиг бөгөөд Сүхбаатар аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй шинээр хэрэгжиж байгаа 21 төсөл, арга хэмжээнээс УЦУОШТ-ийн барилгын засварын ажлын 17.5 сая төгрөгийг БОАЖЯ-аас, 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн дотор халаалтын системийг шинэчлэх засварын ажилд 96.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 180.0 сая төгрөгөөр “**бух**” худалдан авах үүнээс 80.0 сая төгрөгийг 2022 онд, 100.0 сая төгрөгийг 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн үндсэн чиглэлтэй уялдаагүй байна. Бусад шинээр хэрэгжиж буй ТАХ-ний хувьд “Алсын хараа 2050”-тай нийцэж байна.

А.1.2. Төсвийн шууд захирагчдад дээд шатны байгууллагаас олгосон ТАХ-ний санхүүжилт хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцэхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23-р тогтоолоор батлагдсан 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилтын хүрээнд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г хэрэгжүүлэхээр хөтөлбөрт нийцүүлэн төлөвлөсөн. Харин дээд шатны төсөв захирагчаас төсвийн шууд захирагчид эрх шилжин ирсэн ТАХ-ээ нь хөрөнгийн оруулалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй нийцээгүй ажлууд хэрэгжиж байна. Тухайлбал: УЦУОШТ-ийн барилгын засварын ажлын 17.5 сая төгрөгийг БОАЖЯ-аас, 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн дотор халаалтын системийг шинэчлэх засварын ажилд

96.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд 180.0 сая төгрөгөөр бух худалдан авах үүнээс 80.0 сая төгрөгийг 2022 онд, 100.0 сая төгрөгийг 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн үндсэн чиглэлтэй уялдаагүй байна.

А.1.3. Дулаан хангамж, цахилгааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлага, хэт ачаалалд орсон, Өндөрхаан-Баруун-Урт 110кВ-ын ЦДАШ-нд гэмтэл саатал их гардаг, байнга цахилгаан тасалддаг байдлаас шалтгаалан аймагт нэн даруй хийгдэх дараах ажлууд байна. Үүнд:

- Чойбалсан-Баруун-Урт, Өндөрхаан-Баруун-Урт 110кВ-ын ЦДАШ-ын дамжуулагчийн хөндлөн огтлолын талбайг өргөтгөн АС-150 хүртэл нэмэгдүүлэх
- Баруун-Урт сумын “Дэд төв” суурьшлын бүс байгуулахтай холбоотойгоор цахилгаан эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх үүднээс 110кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*10000 чадалтай дэд станц барих
- Эрдэнэцагаан, Халзан, Онгон, Уулбаян сумдад ачааллын өсөлт, дахин төлөвлөлттэй холбоотой 35/10 кВ-ын 1*2500 кВ-ын чадалтай дэд станц шинээр байгуулах

Цахилгааны эх үүсвэрийн дутагдлыг шийдвэрлэх чиглэлээр 13 сум, аймгийн төвийн суурьшлын бүсэд 0,4 шугам татаж, хөрөнгө зарцуулж байгаа боловч хүчин чадлыг нь нэмэгдүүлэхгүйгээр дахин төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэхэд хүндрэл үүсэхээр байна. Харин Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгажээ.

Харин Дөрвөлж ОНӨААТҮГ-ын дулааны станцын хүчин чадал 13 Гкал/ц, нэмэлтээр ажиллуулж буй усан халаалтын 2 зуухны хүчин чадал 9.8 Гкал/ц, нийт суурилагдсан хүчин чадал 22.8 Гкал/ц байгаа боловч хэрэглэгчийн тооцоот ачаалал 30.5 Гкал/ц байна. Суурилагдсан хүчин чадлаас хэрэглэгчдийн тооцоот ачаалал давсны улмаас дулаан хангамжийн системд хэрэглэгч нэмэх боломжгүй болж, цаашид өргөтгөл, шинэчлэл хийх шаардлагатай болсон байна. Үүний дагуу Дулаан хангамж-дулааны станцын засвар үйлчилгээ, өргөтгөлийн ажил 2022 онд эхэлж ажлын явц 10-15 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цаашид дулаан хангамж, цахилгааны эх үүсвэр зэрэг суурь дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт бусад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна. Иймд дулаан хангамж, цахилгааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

А.2. Зарим төсөл арга хэмжээг төсвийн тухай хуультай нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.2.1. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Шинээр хэрэгжиж байгаа 21 ТАХ-г Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 /“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг/ дэх заалтын дагуу төлөвлөж батлуулсан байна.

А.2.2. Холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295-р дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу Монгол улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах Сүхбаатар аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 189,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2022 онд 102,299.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 47 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.

Дээрх журам аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын Цахим системд төсөл арга хэмжээ бүрийн талаарх ерөнхий болон дэлгэрэнгүй мэдээлэл, санхүү эдийн засгийн шинжилгээг хийж холбогдох материалыг хавсаргасан байна.

Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээнээс Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Сүхбаатар/, Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр баг/ төсөл арга хэмжээ нь Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн саналд тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл санал хүргүүлээгүй 2 төсөл арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж, батлагдсан байна.

А.2.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний зураг төсөл батлагдсан боловч зарим ТАХ нь газрын зөвшөөрөл олгогдоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд захиалагчийн үүргийг хэн хэрэгжүүлэх талаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.1.2 /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2-т заасан этгээд захиалагч байна/-т заасан бөгөөд Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2-т “аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна” гэжээ. Өөрөөр хэлбэл улсын төсвийн

хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний зураг төслийн даалгаврыг боловсруулж, батлах хуулийн этгээд нь аймгийн ЗДТГ гэж заасны дагуу ажлын даалгаврыг боловсруулжээ.

Дараах төсөл арга хэмжээнүүд газрын зөвшөөрөлгүй байхад магадлал хийгдэж, төсөвт тусгагдсан байна.

- Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ /Баруун-Урт сум, 1 дүгээр баг/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Баруун-Урт сум/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2.5 км /Сүхбаатар, Халзан сум/
- Баруун-Урт хотын 1 дүгээр баг, цэргийн анги, ахмадын амралт, сувилал орчмын хэсэгчилсэн авто зам, 3.03 км /Сүхбаатар, Баруун-Урт сум/
- Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Сүхбаатар, Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/

Энэ нь Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх /Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна./ заалттай нийцээгүй байна.

Мөн Баруун-Урт сумын 2 дугаар сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилгын цахилгаан, дулааны хангамжийн техникийн нөхцөл олгогдоогүй байхад магадлал хийгдсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана/ заалттай нийцэхгүй байна.

Зарим тохиолдолд төсөл арга хэмжээний төсөвт өртөг улсын төсөвт бүрэн тусгагдаагүйн улмаас барилгын ажил удаашрах, гадна тохижилтын ажлыг орон нутгийн төсвөөс хийх шаардлага гардаг байна. Тухайлбал: Дарьганга сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гадна шугам сүлжээний төсөвт өртөг улсын төсөвт батлагдаагүйн улмаас ажил удааширсан. Халзан сумын цэцэрлэгийн барилгын гадна тохижилтын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлсэн байна.

А.2.4. Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийсэн байна.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал”-ын 2.4.3-т заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч 15.0 тэрбум төгрөгөөс бага төсөвт өртөгтэй буюу ижил төстэй төслүүдийг олноор хэрэгжүүлдэг салбарт тэдгээрийг харьцуулан өрсөлдүүлэх зорилгоор тухайн төслүүдэд зардал-үр дүнгийн шинжилгээ болон хамгийн бага зардлын шинжилгээг хийх гэж заасан байна.

Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёлын төв, дэд бүтцийн шугам сүлжээ зэрэг ажлуудад зардал үр дүнгийн шинжилгээ хийж, бусад төсөл арга хэмжээнүүдийн хувьд хамгийн бага зардлын шинжилгээ хийсэн байна.

А.2.5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 2 төсөл хэмжээнд нэмэлт гэрээ байгуулсан байна.

Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр баг/ төсөл арга хэмжээний хувьд 25.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэмэлт гэрээ, Сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 2 дугаар сургууль/ төсөл арга хэмжээний хувьд 33.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэмэлт гэрээ тус тус байгуулжээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” заалтыг зөрчсөн байна.

Мөн дээрх 2 төсөл арга хэмжээний хувьд төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг ашиглагч байгууллагаас тавьсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх” заалтыг зөрчсөн байна.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ ЗӨРЧЛҮҮД ГАРЧ БАЙНА.

Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зарласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.13-т “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заажээ.

Улсын 2022 оны төсөв 2021 оны 11 сарын 12 өдөр батлагдсан бөгөөд Сүхбаатар аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн 14 төсөл арга хэмжээний эрх шилжүүлэх шийдвэрийн огноог авч үзэхэд 2021.12.01-нээс 2021.12.07-ны хооронд байна. Эндээс үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.13-т заасан хугацаанд эрх шилжүүлжээ.

Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарласан хугацааг авч үзэхэд 2022.01.17-ноос 2022.02.13-ны хооронд зарласан байна. Эндээс дүгнэлт хийхэд төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зарласан байна.

Б.1.2. Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 145 дугаар тушаалаар батлагдсан тендерийн жижиг баримт бичгийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

Аймгийн 80 жилийн ойгоор 260 иргэн, аж ахуйн нэгжээс хандив өгсөн байна. Тухайлбал зарим иргэн, аж ахуйн нэгжийн хандивын талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

<i>Хүснэгт 1. Аймгийн 80 жилийн ойгоор хандив өгсөн иргэн, ААНБ</i>			<i>/сая төгрөг/</i>
№	Ангилал	Иргэн, ААНБ	Мөнгөн дүн
1	Азарга, их насны түрүүлсэн моринд автомашин	2 иргэн	600.0
2	Соёолон, шүдлэн насны түрүү моринд автомашин, мөнгөн хандив	Моннис ХХК	780.0
3	"Сүхбаатар бахархал" цогцолборын бүтээн байгуулалт	Их Модун ХХК	811.4
4	Мөнгөн хандив, Ном хэвлэлийн зардалд	Цайрт минерал ХХК	190.0
5	Баяр наадамд зориулсан рок, попын шоу тоглолтыг зохион байгуулсан	1 иргэн	100.0
6	Хоёр насны морины бай шагнал	1 иргэн	50.0
7	Мөнгөн хандив	Эм Би Би Си ХХК	50.0
8	Шүдлэн насны морины бай шагнал	Жавхлант-Агро ХХК	60.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ, "Сүхбаатарын өнгө" сонин

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно" гэж заасан, мөн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д /Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно/ 25.5.1 /хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн

байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх/ гэж заасан.

Эндээс дүгнэхэд аймаг, орон нутгийн тэгш ойн баяр наадам болон бусад үйл ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллагын болон нийтийн хэрэгцээнд зориулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй хандив, бусад санхүүгийн туслалцаа авсан тохиолдолд хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага **хоёр** жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байхаар байна.

Иймд хоёр жилийн хугацаанд нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтнуудад хандив, бусад санхүүгийн туслалцаа өгөөгүй байх гэсэн шаардлагыг худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тусгах нь зүйтэй байна.

Б.1.3. Тендерт оролцогчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

Тайлант онд шинээр хэрэгжих эрх шилжиж ирсэн 31,212.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээний тендерт оролцогчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

Хүснэгт 2. Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа

			<i>/сая төгрөг/</i>
№	Ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	Нэг удаа тендер шалгаруулалт зохион байгуулсан	6	10,281.7
2	Хоёр удаа тендер шалгаруулалт зохион байгуулсан	7	20,271.6
3	Гурав удаа тендер шалгаруулалт зохион байгуулсан	1	659.2


Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны тайлан

Худалдан авах ажиллагааны хуульд заасны дагуу тендерт оролцогч нар гомдол гаргах эрхтэй бөгөөд 2022 оны эрх шилжин ирсэн ХАА-ны хувьд гомдол гаргаагүй байна.

Б.2. Зарим гүйцэтгэгч комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байна.

Б.2.1. Түвшинширээ сумын 200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга зүгшрүүлэх, ашиглалтын хугацаанд эвдрэл гарсан байна.

Тайлант онд нийт 39,689.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр хуульд тусгагдсанаас 22 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжсэн, 16 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.



Түвшинширээ сумын 200 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 2018 онд “Компорт импекс” ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2019 онд ашиглалтад оруулсан боловч анги, танхимын хана, шал цуурч цэцэрлэг хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл үүссэн байна. Дээрх эвдрэлийг 2020 онд хүчтэй аадар бороо орж гамшгийн хэмжээнд хүрсний улмаас үүссэн гэж аймгийн онцгой комисс дүгнэсэн тул тодорхой зардлыг гамшгийн эрсдэлийн сангаас

шийдвэрлэж, гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгөөр засварыг хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Иймд Аймгийн засаг дарга 2022 онд ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд тус ажлын хэсэг 2023 онд хуралдан зохиогч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулж дараагийн арга хэмжээг авах талаар шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэг өнөөдрийн байдлаар 8 бүлгийн 257 хүүхдийг цууралт багатай 4 бүлэгт хүлээн авч ажиллаж байна.

Б.2.2. Их засварыг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн байна.

Тайлант онд УЦУОШТ-ийн барилгын гадна тал, дээврийн засварын ажлын 17.5 сая төгрөгийг БОАЖЯ-аас, 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн дотор халаалтын системийг шинэчлэх засварын ажилд 96.0 сая төгрөг олгож батлагдсан зураг төсвийн дагуу хугацаанд нь гүйцэтгэжээ.

Б.2.3. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Малын үүлдэр угсааг сайжруулах өсвөр насны үржлийн бух нийлүүлэх” гэрээнд зааснаар 2022 онд 80.0 сая төгрөгөөр 32, 2023 онд 100.0 сая төгрөгөөр 40 швейцарын бор, симменталь, ангус үүлдрийн бух нийлүүлэх гэрээ байгуулж, нийлүүлсэн байна. Мөн дээрх төслийн хүрээнд 653.5 сая төгрөгөөр МТЗ-82.1 трактор 1 ширхэг, ППТ Тукан 1600 хамагч боогч 9 ширхгийг нийлүүлэх гэрээг “Техник хаус” ХХК-тай байгуулж гэрээний дагуу комисс хүлээн авчээ. Эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай автомашиныг Баруун-Урт, Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Онгон сумдад 744.0 сая төгрөгөөр 6 ширхэг LC76 petrol medium маркийн автомашин нийлүүлэхээр “Таван богд” ХХК-тай гэрээ байгуулан гэрээний дагуу комисс ажиллан, хүлээн авсан байна.

Б.2.4. Төсөл, арга хэмжээний “ТЭЗҮ” ангилалд тусгагдсан 1 төсөл, арга хэмжээ байна.

Сүхбаатар аймагтай холбоотой ТЭЗҮ ангиллын 1 төсөл арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Тодруулбал Сумын хөгжил - Инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээний зураг төсөл /Хөвсгөл Рашаант, Цагаан-Уул, Ховд Мянгад, Сүхбаатар Баяндэлгэр/ төсөл арга хэмжээ БХБС-ийн багцаас хэрэгжсэн бөгөөд Сүхбаатар аймгийн ТЭЗ-д эрх шилжин ирээгүй байна.

Б.2.5. Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж он дамжин дуусахгүй орхигдсон 4, орхигдох магадлалтай 1 төсөл, арга хэмжээ байна.

“Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор” болгон шинэчлэх төсөл, арга хэмжээг 1,500.0 сая төгрөгөөр гүйцэтгэгч “МОНСИКОН” ХХК-тай 2020 оны 07-р сарын 07-ны өдрийн БОАЖЯ/202002125 тоот гэрээ байгуулан ажилласан. Өнөөдрийн байдлаар барилгын явц 40 хувьтай, барилгын ажил чанаргүй, зураг, төслийн



дагуу хийгээгүй, хаалга, цонх, модон хийцийн зангилаанууд, барилгын хучилт, дээвэр, хана болон бүх хийцийн дулаалга зураг төслөөс өөр, галын аюулгүй байдлын шаардлага хангаагүй, гэрээний дагуу засвар, шинээр 14м*32м хэмжээтэй хооллох танхимын барилга угсралтын ажлыг эхлээгүй байна. Мөн барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан, холбоо дохиолол, дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуургын хангамжтайгаар гүйцэтгэх байсан боловч хийгээгүй байна. Иймд дээрх барилга нь хэрэгжихгүй орхигдох ТАХ-ний жагсаалтад орох эрсдэл үүсжээ.

Дарьганга сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын төсөвт өртөг 3,271.6 сая төгрөгөөр магадлалын дүгнэлтээр баталгаажсан. Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд тухайн төсөл арга хэмжээний төсөвт өртөг 1,600.0 сая төгрөгөөр батлагдсан тул гадна инженерийн шугам сүлжээгүйгээр зөвхөн барилга угсралтын хэсгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Монмарс холдинг” ХХК 1,599.9 сая төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулсан байна. Барилгын тухай хууль болон барилга угсралтын ажлын норм дүрэм, технологийн дарааллын хувьд гадна шугам сүлжээгүй барилгад цонх, хаалга суулгах дотор засал зэрэг бусад ажлыг гүйцэтгэх боломжгүй тул дээрх ТАХ-ний хувьд дуусахгүй орхигдох магадлал өндөр байна. Иймд тус барилгыг бүрэн ашиглалтад оруулахын тулд магадлалын дүгнэлтээр баталгаажсан үнийн дүнгийн зөрүү 1,671.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, дуусгах шаардлага үүссэн байна.

Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Воркмастер” ХХК 1,940.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч, 2021 оны 6-р сарын 25-нд гэрээ байгуулан ажилласан боловч 2022 оны 10 сарын байдлаар барилгын явц 30 хувьтай, ажил зогссон байна. Тус компанитай байгуулсан

гэрээний 5-р зүйл, гэрээний ерөнхий нөхцөлийн 56-р зүйлд заасны дагуу гэрээг цуцлах нөхцөл үүссэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар 2018-2020 онуудад Эрдэнэцагаан суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Хар үжин” ХХК, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, гүйцэтгэгч “Дэвшилтэд пропортиз” ХХК, Баяндэлгэр суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Оточ ноёдууд” ХХК байна. Эдгээр ТАХ нь цаашид үргэлжлэх боломжгүй болсноор төсвийн хөрөнгө үр ашиггүй болж байгаа тул гэрээний хариуцлага тооцож, гэрээ цуцлах шаардлага үүссэн байна. Дээрх компаниудад гэрээний хариуцлага тооцох, гэрээ цуцлуулах талаар Аймгийн засаг даргаас Боловсролын ерөнхий газрын даргад 2022 оны 9 сарын 16-ны өдөр хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр ирүүлээгүй байна.



Эрдэнэцагаан сум 200 ортой
хүүхдийн цэцэрлэгийн барилга



Баяндэлгэр сум 200 ортой
хүүхдийн цэцэрлэгийн барилга



Эрдэнэцагаан сум 640 хүүхдийн
суудалтай сургуулийн барилга

Б.3. ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ, ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Б.3.1. Барьцаа хөрөнгийн данснаас 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.

Тайлант онд 23 төсөл арга хэмжээний санхүүжилтэд гүйцэтгэлээр 19,627.4 сая төгрөг олгожээ. Үүнээс барилга байгууламжийн 21 төсөл арга хэмжээнд 18,381.4 сая төгрөг, тоног төхөөрөмжийн 2 төсөл арга хэмжээнд 1,246.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт		/сая төгрөг/
№	Ангилал	Төсөвт өртөг
1	Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт	17,853.4
2	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	1,385.1
3	Техникийн хяналтын болон зохиогчийн хяналтын зардалд	296.7
4	Магадалшгүй ажлын зардал	92.2

Эх сурвалж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжиж ирсэн ТАХ-ний гүйцэтгэл

Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх ТАХ-ний хийгдээгүй ажлын үлдэгдэл санхүүжилтийг

Засгийн газрын 2021 оны 397 тоот тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд 844.3 сая төгрөг төвлөрүүлсэн.

Дээрх үлдэгдлээс Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалт /Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ/, Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолын хавсралт журмын 4.2 дахь /Барилга байгууламжийн ажлын санхүүжилт/, 4.2.4 /Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана/ заалтуудыг зөрчин, ажлын гүйцэтгэлгүйгээр 400.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Гүйцэтгэгчээс гэрээг сунгах хүсэлт гаргасны дагуу 2022 оны 9-р сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна. Нэмэлт гэрээний хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй тул 400.0 сая төгрөгийг Аймгийн Засаг даргаас “Монсикон” ХХК-д 2023 оны 01 сарын 15-ны өдрийн дотор барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлэх албан бичиг хүргүүлсэн боловч шилжүүлээгүй байна.

Б.3.2. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан 4 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээний нэмэлт гэрээг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгуулжээ.

Тайлант онд 4 төсөл арга хэмжээний хувьд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан. Сургуулийн барилга, 960 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 5 дугаар сургууль/, Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор /Сүхбаатар, Наран сум/ төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан байна.

Харин 2 төсөл арга хэмжээний нэмэлт гэрээг нь худалдан авах ажиллагааны хэмнэсэн төсвөөр санхүүжүүлсэн байна. Тодруулбал Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр баг/ төсөл арга хэмжээний хувьд 25.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ, Сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум, 2 дугаар сургууль/ төсөл арга хэмжээний хувьд 33.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ тус тус байгуулжээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 13.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь /Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан нэг удаа

өөрчилж болно./ заалтыг тус тус зөрчсөн байна. Энэхүү зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих техникийн улсын хяналт хангалтгүй, ТЕЗ-ийн дотоод хяналт хэрэгжээгүй байна.

Б.4.1. Барилгын техникийн улсын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилгын ажилд захиалагч болон зохиогчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж байгаа боловч техникийн улсын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна. Мөн мал угаалгын ванн, инженерийн хийцтэй гүний худаг зэрэг төсөл арга хэмжээнүүдэд захиалагчийн техникийн хяналт хэрэгжээгүй байна.

Тодруулбал “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9-д “Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу **барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх** зорилгоор тухай бүр хийсэн байна.” гэж заасан.

Мөн Барилгын тухай хуулийн 6 дугаар бүлэгт зааснаар “**Барилгын үйл ажиллагаанд оролцогч**” гэдэгт иргэн, төрийн бус байгууллага, захиалагч, зураг төсөл зохиогч, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт, барилгын ажил гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд, барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч орохоор байна. Харин Барилгын тухай хуулийн 7 дугаар бүлэгт “**Техникийн улсын хяналт**”-тай холбоотой харилцааг зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл барилгын хяналтын улсын байцаагч нь барилгын үйл ажиллагаанд оролцогч биш бөгөөд техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд байна. Иймд захиалагч, захиалагчийн хяналт тавих байгууллага нь барилгын ажилд барилгын хяналтын улсын байцаагчтай хамтарсан үзлэг шалгалтыг хийхээр байна. Гэтэл Сүхбаатар аймагт барилгын ажилд тавих техникийн улсын хяналт хангалтгүй байна.

Б.4.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь /Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ/, 14.2.10 /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/ заалтын хүрээнд Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын үйл ажиллагааг Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудит хариуцсан харьяа байгууллагатай боловч тус байгууллага нь улсын төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудит хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” заалтын хэрэгжилтийг хангахгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй шалтгааныг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны холбогдох албан тушаалтнуудаас тодруулахад үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд батлагддаггүй байсантай холбоотой байна. Төрийн аудитын байгууллагын зөвлөмж, Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу цаашид хөрөнгө оруулалтад жил бүр санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж байхаар болсон байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын **гүйцэтгэлд хяналт, шалгалт, дотоод аудит хийх**” гэж тусгасан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хяналт, шалгалт, дотоод аудитад хамрагдахгүй байх эрсдэлтэй байна. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, үр дүнг бүрэн хамруулсан байдлаар санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудит хийх талаар зөвлөмж өглөө.

Б.5. Зарим төсөл арга хэмжээний хувьд улсын комиссын үүрэг даалгавар биелээгүй байна.

Б.5.1. Зарим төсөл арга хэмжээний хувьд улсын комиссын үүрэг даалгавар биелээгүй, барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд зөрчил гарсан байна.

Наран сумын сургуулийн 50 ортой хүүхдийн дотуур байрны 863.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний гүйцэтгэгчээр “Ай ди си” пропорти ХХК шалгарч Аймгийн засаг даргын 2021 оны 10 сарын 8-ны өдрийн захирамжаар 20 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс байгуулсан. Улсын комисс тус барилгад 65 ажил хийж гүйцэтгээгүй байгааг дуусгах үүрэг даалгавар гүйцэтгэгч компанид өгсөн боловч бүрэн хийгээгүй байна. Тухайлбал: Үерийн ус зайлуулах бетон суваг хийх, үүдний саравч дээр ус зайлуулах налуу хийж хар цаас наах, гадна кабель солих, хоол үйлдвэрлэлийн өрөөний гүйцэтгэл дутууг гүйцээх зэрэг ажлууд байна.

Мөн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2021 оны 11 сард комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж үзэхэд биелэлт

хангалтгүй байгааг ХБТХОХ-т 2021 оны 11 сарын 30-ны 1/396 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Иймд барьцаа хөрөнгийн дансанд байгаа 41.0 сая төгрөгийг комиссоос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсний дараа олгож барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс дахин ажиллуулах шаардлагатай байна.

Түүнчлэн зарим төсөл арга хэмжээний ашиглагч байгууллагаас ирүүлсэн барилгын чанар байдлын мэдээллийг авч үзэхэд барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгавар бүрэн биелээгүй болон бусад зөрчил гарсан байна. Тухайлбал Онгон сумын 160 хүүхдийн сургуулийн барилга /Интернэт шугам сүлжээний ажил дутуу, халаалтын шугам сүлжээ 4 хэсэг газар буруу хийгдсэн, спорт заалны дээд талаас ус гоождог/, Уулбаян сумын сургуулийн дотуур байрны барилга /халаалтын тень, бойлер шатсан, охидын халуун ус ажилддаггүй, дээврээс ус гоождог/ байна.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах нэг жилийн хугацаанд Барилгын тухай хуулийн 14.8-д заасны дагуу 5-10 хувийг барьцаалахаар заасан. Сүхбаатар аймгийн хувьд тухайн барилгын ашиглагч байгууллагаас албан бичиг авсны үндсэн дээр чанарын баталгаат хугацааны барьцааг чөлөөлж байгаа нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх /Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ./ 14.5 дах /Энэ хуулийн 14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно./ заалттай нийцэхгүй байна.

Тодруулбал хамтарсан үзлэг, шалгалт хийгээгүй байхад барьцаа хөрөнгийг чөлөөлөх үндэслэлгүй байна. Иймд хамтарсан үзлэг шалгалт хийж, тухайн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тохиолдолд чанарын баталгаат хугацааны барьцааг чөлөөлж байх, мөн чанарын баталгаат хугацааны барьцаагүй барилгын ажлыг ашиглалтад хүлээн авснаас хойш 1 жилийн дараа хамтарсан үзлэг шалгалт хийж байхыг тус тус зөвлөмж болголоо.

Б.5.2. Гэрээний үүргээ биелүүлээгүй үндэслэлээр гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээг захиалагч тал цуцлахаар шийдвэрлэсэн 1 төсөл арга хэмжээ байна.

Тайлант онд эцсийн санхүүжилтээ авсан 9 төсөл арга хэмжээнээс гэрээний хугацаа хэтэрсэн 1 төсөл арга хэмжээ байна. Тодруулбал Наран сумын сургуулийн 50 ортой дотуур байрны барилгын ажил гэрээний хугацаанаас 98 хоног хэтэрсэн боловч гэрээг дүгнэхдээ Ковид 19 цар тахалтай холбоотойгоор ажлын гүйцэтгэл удааширсан, ажиллах хүчний хомсдол, бараа материалын үнийн өсөлт, үйл ажиллагаа зэргийг харгалзан алданги тооцохгүй байхаар шийдвэрлэжээ.

Энэ нь Иргэний хуулийн 208 дугаар зүйлийн 208.1 дэх “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ” заалттай нийцэхгүй байна. Харин Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.1-д /Дараах тохиолдолд үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ/ 222.1.1 /үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол/ 222.1.2 /үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг үүрэг гүйцэтгүүлэгч сануулснаас хойш үүргээ биелүүлээгүй бол/ заасан байна. Тодруулбал гэрээний хугацаа дууссанаас хойш захиалагч үүрэг гүйцэтгэх хугацаа болсныг гүйцэтгэгч компанид ямар нэг хэлбэрээр сануулснаас хойш ажлаа хийгээгүй бол хугацаа хэтрүүлсэн гэж үзэж алданги тооцох, харин ажлаа хийсэн бол хугацаа хэтрүүлсэн гэж үзэхээргүй буюу алданги тооцохооргүй зохицуулалтай байна.

Мал угаалгын суурин ванн /Сүхбаатар/ төсөл, арга хэмжээний тендерт Том ноёд ХХК шалгарч 190.1 сая төгрөгөөр 2020.07.09 өдөр гэрээ байгуулж, гэрээний дуусах хугацааг 2021.11.09 хүртэл сунгасан боловч мал угаалгын 21 ванн хийхээс 8-ийг хийж, 13 ванныг хийгээгүй байна. Иймд АЗДТГ-аас гэрээний хугацаа сунгалгүйгээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн байна.

Б.5.3. Эцсийн санхүүжилт олгохоос өмнө барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгасан байх шаардлага бүрэн хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнээс ашиглалтад хүлээн авсан 9 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан, 6 төсөл арга хэмжээний хувьд ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт 4. Данс бүртгэлд тусгаагүй эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг
1	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Сүхбаатар/	653.5
2	Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ /Сүхбаатар, Баруун-Урт сум, 1 дүгээр баг/	314.1
3	Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Баруун-Урт сум/	345.2
4	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Баруун-Урт сум/	1,231.8
5	Сургуулийн барилга буулгаж, барих, 160 суудал /Сүхбаатар, Онгон сум, 2 дугаар байр/	1,637.9
6	Баруун-Урт хотын 1 дүгээр баг, цэргийн анги, ахмадын амралт, сувилал орчмын хэсэгчилсэн авто зам, 3.03 км /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2,869.3

Эх сурвалж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэл

Эрх шилжиж ирээгүй төсөл арга хэмжээнээс ашиглалтад хүлээн авсан 5 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан, 2 төсөл арга хэмжээ /Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах, Цагдаагийн хэлтсийн барилга/-ний хувьд ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.31-д “Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана” гэж заасан боловч энэ заалт хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ В. ТӨЛӨВЛӨЛТ, ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙГ ЭС ТООЦВОЛ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй зөрчлүүд гарч байна.

В.1.1. Сүхбаатар аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдаагүй 4 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 19 төсөл арга хэмжээнээс Сүхбаатар аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдаагүй дараах төсөл арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Өвс тэжээл нөөц бүрдүүлэх, өр барагдуулах
- Гэр төсөл хэрэгжүүлэх/ Баруун-Урт, Халзан, Уулбаян, Дарьганга/
- Гэр төсөл хэрэгжүүлэх / Баруун-Урт сум/
- Гэр дулаалга хөтөлбөр хэрэгжүүлэх / Баруун-Урт сум 3-р баг/

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, 6.10.1, 6.10.4 дэх заалттай нийцэхгүй байна.

В.1.2. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 510.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ, магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй 492.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын шинж чанаргүй зарим төсөл арга хэмжээнүүд батлагдсан байна.

Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг
1	Өвс тэжээл нөөц бүрдүүлэх, өр барагдуулах	100.0
2	Гэр төсөл хэрэгжүүлэх/ Баруун-Урт, Халзан, Уулбаян, Дарьганга/	170.0
3	Гэр төсөл хэрэгжүүлэх / Баруун-Урт сум/	30.0
4	Гэр дулаалга хөтөлбөр хэрэгжүүлэх / Баруун-Урт сум 3-р баг/	70.0
5	Хилийн торны шинэчлэл / Эрдэнэцагаан сум/	70.0
6	Хилийн торны шинэчлэл / Онгон сум/	70.0

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Эдгээр төсөл, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих

хөрөнгийн зарлагыг/ дахь заалттай нийцээгүй байна. Мөн “Хилийн торны шинэчлэл-Эрдэнэцагаан сум”, “Хилийн торны шинэчлэл-Онгон сум” төсөл арга хэмжээнүүд зардлын шинж чанартай бөгөөд данс бүртгэлд хөрөнгөөр бүртгэдэггүй байна. Өөрөөр хэлбэл эдгээр ТАХ нь төсвийн хөрөнгө оруулалтын тодорхойлолтой нийцэхгүй байна.

Мөн аймгийн 2023 оны орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад 350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэр төсөл хэрэгжүүлэх” төсөл арга хэмжээ батлагдсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалттай нийцэхгүй байна. Иймд орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтаас хасах, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хүрээнд шийдвэрлэх боломжтой төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх зөвлөмж өглөө.

Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тодруулбал магадлалаар баталгаажсан зураг төсөлгүй 492.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг орон нутгийн төсөвт тусгаж баталжээ.

Хүснэгт 6. Төсөв батлагдахаас өмнө зураг, төсөв нь баталгаажаагүй ТАХ /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг
1	Жимс жимсгэнэ үржүүлгийн газрын цахилгаан 10/04 кВ-ын 50 кВа чадалтай агаарын КТПН дэд өртөө /Баруун-Урт сум/	36.0
2	Ус цаг уур орчны шинжилгээний албаны барилгын засвар	33.0
3	Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны шалны засвар /Уулбаян сум/	20.0
4	Цэцэрлэгийн барилгын их засвар /Баруун-Урт сум, 3-р цэцэрлэг/	290.0
5	Боловсрол өргөө нэгдсэн дотуур байрны дээврийн их засвар /Баруун-Урт сум/	113.3

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2. /барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх/ заалттай нийцэхгүй байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

В.2.1. Тендерийн баримт бичигт хандивтай холбоотой нэмэлт шаардлага оруулах нь зүйтэй байна.

Аймгийн 80 жилийн ойн арга хэмжээ болон бусад үйл ажиллагааны хүрээнд аймаг, орон нутагт хандив, бусад санхүүгийн туслалцаа үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хамаарал бүхий компаниуд орон нутгийн төсвийн хөрөнгөөр зарлагдсан тендерт оролцож, шалгарах, гэрээ байгуулах эрсдэл байгаа тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.1 дэх заалтыг үндэслэн цаашид тендерийн баримт бичигт хандивтай холбоотой нэмэлт шаардлага оруулах нь зүйтэй байна.

Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 16 худалдан авах ажиллагаа тайлант онд зохион байгуулагдсанаас 1 тендертэй холбоотой гомдол гарсан байна. Тодруулбал Цэцэрлэгийн барилгын их засвар /Баруун-Урт сум, 3-р цэцэрлэг/ төсөл арга хэмжээний тендерт оролцсон “Хүрэл соёмбо” ХХК нь гомдол гаргасан бөгөөд Сангийн яам хянаж үзээд үнэлгээний хорооны шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Тайлант онд 1,129.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж, нийт 1,000.8 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, 128.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны хэмнэлт бий болсон байна.

В.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 77.8 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалтад батлагдсан 20 төсөл арга хэмжээнээс хэрэгжиж дууссан 14 төсөл арга хэмжээ, 66-90 хувийн гүйцэтгэлтэй 2 төсөл арга хэмжээ, хэрэгжээгүй 4 төсөл арга хэмжээ байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 77.8 хувьтай байна.

Хүснэгт 7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй ТАХ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тайлбар
1	Тусгай зориулалтын автомашинуудын автограш барих /Онцгой байдлын газар/	Тендер 3 удаа зарласан компани оролцоогүй
2	Сүхбаатар аймгийн 80 жилийн ойд зориулсан музейн сан хөмрөгийг баяжуулах, мөнгөн урлалын үзэсгэлэн зохион байгуулах	Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй
3	Гэр дулаалга хөтөлбөр хэрэгжүүлэх /Баруун-Урт сум 3-р баг/	Тендер 2 удаа зарласан компани оролцоогүй
4	Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны шалны засвар /Уулбаян сум /	Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон байна.

Орон нутгийн төсвөөс 16 төсөл арга хэмжээний санхүүжилтэд нийт 1,161.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хэрэгжилт дутуу төсөл 476.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 360.1 сая төгрөг байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын олгосон санхүүжилт /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн дундаж хувь	Олгосон санхүүжилт
1	Барилга байгууламж	1	100	35.4
2	Их засвар	5	91.2	695.4
3	Тоног төхөөрөмж	10	100	431.1

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

В.2.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд техникийн улсын хяналт болон ТЕЗ-ийн дотоод хяналт хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч техникийн улсын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна. Энэ нь “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9 дэх заалттай нийцэхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудит алба хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” заалттай нийцэхгүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт, шалгалт, дотоод аудит хийх” гэж тусгасан байна.

Эндээс үзэхэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хяналт, шалгалт, дотоод аудитад хамрагдахгүй байх эрсдэлтэй байна. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, үр дүнг бүрэн хамруулсан байдлаар санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудит хийх талаар зөвлөмж өглөө.

В.2.5. Данс бүртгэлд тусгаагүй 4 төсөл арга хэмжээ байна.

Ашиглалтад хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгаагүй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Аймгийн төвийн худалдааны төвүүдэд камержуулалт / Баруун-Урт сум/
- Жимс жимсгэнэ үржүүлгийн газрын цахилгаан 10/04 кВ-ын 50 кВа чадалтай агаарын КТПН дэд өртөө /Баруун-Урт сум/

- Ус цаг уур орчны шинжилгээний албаны барилгын засвар
- Боловсрол өргөө нэгдсэн дотуур байрны дээврийн их засвар/ Баруун-Урт сум/

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.31-д “Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана” гэж заасан боловч энэ заалт хэрэгжээгүй байна.

Цаашид Засаг даргын нөөц сангаас бэлтгэж, ЗДТГ-ын данс бүртгэлд бараа материалаар бүртгэж, журмын дагуу иргэд, малчдад олгож байх шаардлагатай дараах төсөл арга хэмжээнүүд байна. Тухайлбал “Гэр төсөл хэрэгжүүлэх”, “Өвс тэжээлийн нөөц бэлтгэх” гэх мэт төсөл арга хэмжээ байна. Иймд энэхүү асуудлаар холбогдох байгууллагуудад зөвлөмж өглөө.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:

**СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТЭС**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг

Утас, факс:

2023.04.18

№

05/515

танай

-ны №

-т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагыг шат шатандаа хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэн ажиллана.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

[Signature]

ХЭНХЦЭЦЭГ



Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Холбогдох байгууллагаас ирсэн саналд тайлбар байхгүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгавар, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцох, гэрээг цуцлах шаардлага үүссэн байна.
2. Зарим ТАХ-ний хувьд магадлалын дүгнэлтээр баталгаажсан үнийн дүнгээс төсөв нь бага батлагдсанаас шалтгаалж дуусаагүй орхигдох, хэрэгжилт удаашрах эрсдэл байна.
3. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийсэн байна.
5. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн гэр төсөл, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, өр барагдуулах ТАХ-нүүд нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:

1. Хамтарсан үзлэг шалгалт хийж, тухайн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тохиолдолд чанарын баталгаат хугацааны барьцааг чөлөөлж байх.
2. Чанарын баталгаат хугацааны барьцаагүй барилгын ажлыг ашиглалтад хүлээн авснаас хойш 1 жилийн дараа хамтарсан үзлэг шалгалт хийх.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн гэр төсөл, өвс тэжээлийг Аймгийн Засаг даргын нөөц сангаас бэлтгэж, данс бүртгэлд тусгах.
4. Байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгавар, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцон, гэрээг цуцлах.
5. Аймаг, орон нутгийн тэгш ойн баяр наадам болон бусад үйл ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллагын болон нийтийн хэрэгцээнд

зориулан холбогдох хуульд заасан хязгаарлалтад хамаарахгүй хандив, бусад санхүүгийн туслалцаа авсан тохиолдолд хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага **хоёр жилийн хугацаанд** хандивлагчтай холбоотой **аливаа шийдвэр гаргахгүй байх**, мөн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжүүлж буй этгээдээс хандив, тусламж авахгүй байх.

6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний зураг төсөв нь магадлалаар баталгаажсан байх хуулийн шаардлагыг хангахын тулд шат шатны албан тушаалтнуудад энэ чиглэлээр мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, үр дүнг бүрэн хамруулсан байдлаар санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх.

Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан ТАХ-г холбогдох байгууллагуудын данс бүртгэлд тусгах ажиллагааг тайлант онд нь багтаан хийх.
2. Албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагад сүүлийн 2 жилийн хугацаанд хандив, тусламж, бусад санхүүгийн туслалцаа үзүүлээгүй байх гэсэн шаардлагыг төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт тусгаж байх.

Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:

1. Зарим төсөл арга хэмжээний магадлалаар баталгаажсан төсөвт өртөг улсын төсөвт бүрэн тусгагдаагүйн улмаас барилгын ажил удаашрах, дуусахгүй орхигдох эрсдэл байгааг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах.
2. Боловсрол, соёл шинжлэх ухааны яамнаас эрх шилжиж ирээгүй дараах ТАХ-үүд гүйцэтгэгчээс шалтгаалж ажил зогссон, цаашид хэрэгжих боломжгүй болсон тул гэрээний хариуцлага тооцож, гэрээ цуцлах шаардлага үүссэн байна. Үүнд: Эрдэнэцагаан суманд 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Хар үжин” ХХК, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, гүйцэтгэгч “Дэвшилтэд пропортиз” ХХК, Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Воркмастер” ХХК, 200 ортой хүүхдийн цэцэрлэг, гүйцэтгэгч “Оточ ноёдууд” ХХК байна.

---oOo---